



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ**

2025 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/17.

Батширээт сум

Ур чадварын нэмэгдэл олгох тухай

“Монгол Улсын Боловсролын ерөнхий хууль”-ийн 33 дугаар зүйлийн 33.3.3, Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, “Төсвийн тухай хууль”-ийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жижүүрийн албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийн биелэлт, хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчилгүй ажиллахаас гадна байгууллагын архив, бичиг хэргийн ажлыг хангалттай сайн гүйцэтгэн ажиллаж байгаа Ө.Сарантуулд цалингийн 25 хувиар ур чадварын нэмэгдэл олгосугай.

2. Ө.Сарантуулын ур чадварын нэмэгдлийг цалингийн санд багтаж байвал 2025 оны 09 дүгээр сараас үндсэн цалингийн хэмжээнээс тооцож олгохыг нягтлан бодогч М.Ууганжаргалд зөвшөөрсүгэй.

ЭРХЛЭГЧ

А.ХАНДЦОО

